

## **ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 20120 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

### **ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН:**

Зарим хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах тухай, Хүн ам, байшин орон сууц, мал тооллогын дүнгийн талаарх мэдээлэл, 2020 онд ОНХС, АЗС, БОХНСЗ болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Дорнод аймагт хийгдэх хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, Орон нутгийн өмчийн асуудлууд, Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарын цалинг тогтоох тухай асуудлуудыг тус тус хэлэлцэн батлав.

### **БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн Дорнод аймгийн мандатыг хуучин хэвээр нь 3 болгон нэмэгдүүлэх саналаа холбогдох газруудад хүргүүллээ.

“ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ЗӨВЛӨЛ”-ийн хуралдаан боллоо

Дорнод аймгийн төр хувийн хэвшлийн зөвлөл өнөөдөр хуралдаж 2020 онд хийх ажлын төлөвлөгөө, ажиллах журмаа баталлаа.

Төр хувийн хэвшлийн зөвлөл нь Төр, хувийн хэвшлээс тус бүр 10 хүний тэнцүү төлөөлөлтэй байх бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга ахлан ажилладаг юм.

Зөвлөл нь хувийн хэвшлийн тулгамдсан асуудлуудыг төрийн бодлого шийдвэрт тусгуулан хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах зорилготой.

## **Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган Монгол Улсын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 95.4 хувь, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 84.1 хувийн дундаж үнэлгээтэй тус тус гаргаж аймгийн Засаг даргын 2020 оны 01, 04 дүгээр Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн [new.unelgee.gov.mn](http://new.unelgee.gov.mn) сайтад байршууллаа.

## ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

Орон нутгийн нийторлого 8665.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 8290.6 сая төгрөг, үүнээс татварын орлого 1441.8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 1811.3 сая төгрөгт хүрч 369.5 сая төгрөгөөр давж, татварын бус орлого 981.3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 1041.7 сая төгрөгт хүрч 60.3 сая төгрөгөөр давж биеллээ.

### Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	Хувь
			Тоо	
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	8,665,198,900.00	8,290,685,753.00	(374,513,147.00)	95.7
003 ТАТВАРЫН ОРЛОГО	1,441,806,900.00	1,811,317,475.31	369,510,575.31	125.63
004 Орлогын албан татвар	1,014,356,400.00	1,270,256,641.77	255,900,241.77	125.23
016 Хөрөнгийн албан татвар	61,284,400.00	26,608,246.56	(34,676,153.44)	43.42
021 Бусад татвар, төлбөр, хураамж	366,166,100.00	514,452,586.98	148,286,486.98	140.50
041 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,768,680,900	15,399,138,800	9,855,769,700	97.66
042 Нийтлэг татварын бус орлого	176,482,800.00	239,124,852.81	62,642,052.81	135.49
049 Хөрөнгийн орлого	0.00	220,000.00	220,000.00	#DIV/0!
056 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	5,543,369,100	5,173,827,000	(369,542,100.00)	93.33
058 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	4,371,447,300.00	4,371,447,300.00	-	100.0
059 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	367,042,100.00	0.00	(367,042,100.00)	-

## ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 9017,1 сая төгрөгтөлөвлөгдсөнөөс 5243,4 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

### Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%
- ✓ Тогтмол зардалд 18,3%
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 804,9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 4371,4 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ.

## Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,017,060,800.00	5,243,412,351.00	(3,773,648,449.00)	58.1
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	3,970,970,100.00	2,801,780,305.46	(1,169,189,794.54)	70.6
Ажиллолгогчооснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	534,984,600.00	346,831,655.59	(188,152,944.41)	64.8
Бараа үйлчилгээний бусад зардал	491,463,100.00	92,159,265.00	(399,303,835.00)	18.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	365,241,700.00	281,695,971.20	(83,545,728.80)	77.1
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,046,806,600.00	203,266,566.00	(843,540,034.00)	19.4

## **Дөрөв. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, аймгийн Засаг даргын 503 захирамжид виз өгч, 7 сумын Засаг даргын 173 захирамж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 31 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянан гарсан зөрчил, дутагдалд 4 удаагийн зөвлөмж хүргүүлээд байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 13 өргөдөл ирүүлснээс 7 өргөдөл гомдлыг шийдвэрлэн холбогдох хариуг иргэдэд өгч ажилласан. Аймгийн Засаг даргад хандан мөнгөн тусламж хүссэн 4 иргэнд 400.000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгөөс олгуулах ажлыг зохион байгуулаад байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/501 дугаартай захирамжаар батлагдсан “Таван-эрдэнэ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалтыг хэлэлцэх зорилгоор “Хэл, Хил, Мал гуравтайгаа байхад хэн баян Монгол баян” малчдын чуулга уулзалтыг 2019 оны 11 сарын 04-ний өдөр зохион байгууллаа.

Малчдын чуулганд аймгийн мал сүргийг хулгайн гэмт халдлагаас хамгаалах Монголын нийгэмлэгийн тэргүүн Ц.Анандбазар, нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн Монгол улсын Хөдөлмөрын баатар, Тод манлай уяач Д.Даваахүү болон аймгийн төрийн захиргааны болон агентлагын дарга нар мөн сумдын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга, хэсгийн төлөөлөгч, 14 сумын малчин иргэдийн төлөөлөл зэрэг 160 гаруй иргэд оролцсон байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн А/201 дугаар захирамжаар батлагдсан Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр нийт 16 гишүүнээс 15 гишүүн ирж 99%-ийн ирцтэйгээр хуралдсан. Тус хурлаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь 2019 онд гэмт хэрэг зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ, хийж хэрэгжүүлсэн ажлын тайлантай танилцаж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг хэлэлцлээ. .

### **Архивын чиглэлээр:**

Аймгийн Архивын тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шат /2017-2020/-нд гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### 1. Албан хэрэг хөтлөлт, хууль тогтоомж, шийдвэрийн талаар:

Архивын тасагт 2020 оны 1 дүгээр сарын 31-ний байдлаар ирсэн 7 албан бичгийг хүлээн авч бүртгэн, гадагш 5 тодорхойлолт, 5 албан бичиг боловсруулж явуулсан байна. 2 хариутай бичгийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

#### 2. Баримт ашиглалтын талаар:

1 дүгээр сард 319 иргэнээс лавлагаа мэдээллийн захиалга хүлээн авч 1023 хуулбар, 50 тодорхойлолт, 37 иргэнд 307 оны малын А данс гаргаж нийт 4 965 400 төгрөгийн орлого оруулав. Хадгаламжийн сангаас 194 хөмрөгийн 611 хадгаламжийн нэгжийг гаргаж ашиглан бүртгэж буцаан байрлуулав. Мөн 2 судлаачид Мах комбинатын архивын баримтаас 1994-2004 оны захиралын тушаал 12 ХН, Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн архивын баримтаас 1991-2005 оны 11 ХН олгож ашиглуулав.

2020 оны 1 дүгээр сарын 31-ны өдрөөс 31-ийн өдөр 88 өдөр 15 35 196 өдөр 3 360 500 өдөр 47 өдөр 1 786 600 өдөр 1 өдөр байна.

Шинээр 2 байгууллагын материалыг хүлээн авч эх хувийг бэлтгэн стандартын дагуу хэвлэж өгөв.

#### 3. Нөхөн бүрдүүлэлт

“Ган-октаэдр” ХХК хийж гүйцэтгэсэн Хэрлэн сумын 8 дугаар багийн орон сууцны нийтийн эзэмшлийн шугамыг цэвэр усны төвлөрсөн шугамд холбох ажилд хамаарах 1 ХН, мөн Хэрлэн сумын 10 дугаар багийн байрны барилгын ажлын гүйцэтгэл 3 ХН, “Сүхжин” ХХК-ны хийж гүйцэтгэсэн Хэрлэн сумын 4 дүгээр багийн ажлын албаны байр, 15 дугаар цэцэрлэг, Хүний хөгжлийн ордны гадна шугам сүлжээний ажлын материал 8 ХН буюу нийт зураг төслийн 3 байгууллагын 12 ХН бүхий 838 хуудас баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүллээ.

#### 4. Цахим хэлбэрт оруулсан баримтын талаар:

2020 онд цахимжуулах төлөвлөгөөг боловсруулж, сар, улирал, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

- Цахим холболт- 84 хадгаламжийн нэгжийн 10619 хуудас баримт
- Хүний нэр-18912
- Агуулга-8170
- Байгууллагын нэр-27
- Газар зүйн нэр-343

## 5. Зөвлөгөө, сургалт

Аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн С. Урантогосд архивын баримтын хадгалах хугацааг зөв тогтоох, ХН бүрдүүлэх, ХХНЖ үйлдэх, ББНШК-ийн хурлын тэмдэглэл бичих талаар заавар зөвлөгөө өгөв.

Аймгийн Мал эмнэлэгийн газрын хүсэлтээр нийт мэргэжилтнүүдэд болон сумдын мал эмнэлэг үржлийн тасгийн ажилтан 25 хүнд “Баримт бичиг боловсруулах арга зүй”, “Архивын баримтаар байгууллагын архивыг нөхөн бүрдүүлэх арга зүй” сэдвээр сургалт өгөв.

## 6.Бусад

Баримтын өөрчлөлт хөдөлгөөний статистик тайланг гаргаж Архивын ерөнхий газарт хүргүүлэв.

1 дүгээр сард “Анна номе” хүүхдийн асрамжийн төвийн барилга, “ХААН ХҮНС” ХХК-ны Мах бэлтгэх худалдааны төвийн барилга хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллав.

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 1 дүгээр сарын 3, 24-ны өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 1 дүгээр сарын 9,16,30-ны өдрүүдэд хөтөлж ажилласан.

**Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**  
***Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг***  
***Биеийн тамир, спортын газар***

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 27 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өвлийн спортын төрлөөр бүх нийтийн өдөрлөг зохион байгуулж иргэдийг чөлөөт цагаараа цасны спортоор хичээллэн өнгөрүүлэх боломжоор хангах зорилгоор “Дэлхийн цасны өдөр”-ийг Монгол Улсад 6 дахь жилдээ тэмдэглэн өнгөрүүлж байна. Энэ жилийн арга хэмжээнд Дорнод аймгийн төрийн болон төрийн бус, аж ахуй нэгжийн 19 байгууллага, 5 суманд нийт 843 ажилчин, албан хаагчид оролцлоо.

***Биеийн тамир, спортын арга хэмжээ:***

Самбо бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 01 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд Улаанбаатар хотод болж, Дорнод аймгийн баг, тамирчид 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр 4 дүгээр байрт шалгарсан.

Зүүн бүсийн U 13-14 насны хөлбөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээн Дорноговь аймагт 01 дүгээр сарын 06-12, 14-25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Дорнод аймгийн 1 дасгалжуулагч хөвгүүдийн 2 багийн 21, охидын 10 тамирчид амжилттай оролцов.

“Туухай өргөлт 2020” Улаанбаатар хотын аварга шалгаруулах нээлттэй тэмцээн 2020 оны 01 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд “Аврагч” Биеийн тамир, спорт хорооны зааланд зохион байгуулагдаж, Дорнод аймгийн Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн баг, тамирчид амжилттай оролцож, 1 алт, 3 мөнгө, 1 хүрэл медаль хүртэв.

***Аймаг, орон нутагт болсон биеийн тамир, спортын арга хэмжээ:***

Аймгийн аварга шалгаруулах насанд хүрэгчдийн бадминтоны тэмцээн 2020 оны 01 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 7 байгууллагын эрэгтэй 26, эмэгтэй 21, нийт 47 тамирчид оролцов.



Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсны 28 жилийн ойн өдөрт зориулсан үндэсний бөхийн барилдаан Дорнод аймгийн Чойбалсан, Баян-Уул, Цагаан-Овоо суманд зохион байгуулагдаж, цолгүй бөхийн барилдаанд 63, сумын цолтой бөхийн барилдаанд 92 бөхчүүд тус тус оролцов.

### ***Сургалт, семинар:***

Улаанбатар хотод 01 дүгээр сарын 04-ны өдөр зохион байгуулагдсан футзалны шүүгчийн сургалтад 2 хүн хамрагдав.

Самбо бөхийн улсын шүүгчийн сургалтад аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газраас 1 шүүгч хамрагдаж улсын шүүгчийн сертификаттай болсон.

Хэнтий аймагт зохион байгуулагдсан “World Friends” таеквондогийн сургалт, семинард 2 дасгалжуулагч, 3 тамирчин оролцов.

Волейболын дасгалжуулагч Ч.Мөнхбатаа охид, хөвгүүдийн нийт 22 бүрэлдэхүүнтэй баг, тамирчид Хэнтий, Сүхбаатар аймгуудад хамтарсан бэлтгэл сургуулилтад хамрагдаж, туршлага солилцов.

### ***Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл, урлагийн газар***

### ***Хурал, зөвлөгөөн, уулзалт, ярилцлага:***

Шинэ төрлийн коронавирусийн дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдтай тархаж байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газрын дарга А.Нансалмаа болон холбогдох мэргэжилтнүүд 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр 13 сумын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн захирал, эрхлэгч нартай онлайн хурал зохион байгуулж, Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яам болон аймгийн Онцгой комисс, Засаг даргын зүгээс баталсан тогтоол, тушаал шийдвэрийг танилцуулан мэдээлэл, зөвлөмж, чиглэл өгөв.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар хамтран “Мэдээллийг эх сурвалжаас нь” сэдвийн дор коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар аймаг, орон нутаг, холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны тухай танилцуулах хэсэгчилсэн уулзалтыг 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулав.

Цаашид долоо хоног бүрийн Лхагва гарагт аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газрын 101 тоот өрөөнд тогтмол зохион байгуулахаар тогтов.

Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг 2020 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах санал солилцох уулзалтыг аймгийн Төв номын сан, Музейн мэргэжилтнүүд, зарим сумдын Соёлын төвийн эрхлэгч нарыг оролцуулан 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газарт зохион байгуулав.

Энэ онд сумдын Соёлын төвүүд баруун, зүүн, төвийн гэсэн 3 бүсэд хуваарилагдан улсын болон орон нутгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн олон нийтэд соёл, урлагийн үйлчилгээг чанартай хүргэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа харилцан туршлага солилцож, уялдаа холбоогоо улам бэхжүүлэн ажиллахаар болов.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн цай, цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанар, ариун цэвэр, эрүүл ахуй, хүртээмжийг сайжруулах, хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих, шаардлагатай илчлэг, шим тэжээл бүхий хоол хүнсээр хангах, норм, стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Дорнод аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн тогооч нарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх уулзалт 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газарт болов. Уг үйл ажиллагааг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хэрлэн сумын сургууль, цэцэрлэгүүдийн тогооч нарын мэргэжил арга зүйн зөвлөл хамтран зохион байгуулж санал солилцлоо.

### ***Сургалт, семинар, хэлэлцүүлэг:***

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан багшийн хөгжлийг дэмжих “Эрдэм” хөтөлбөр, аймгийн Засаг даргын дэмжлэгээр Халхгол сумын сургууль, цэцэрлэгийн багш ажилчид, Ялалт багийн сургуулийн цэцэрлэгийн багш, Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн Монгол хэлний багш нарын нийт 75 хүн хамрагдсан “Багшийг ажлын байранд нь хөгжүүлэх” сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулав.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн цай, цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанар, ариун цэвэр, эрүүл ахуй, хүртээмжийг сайжруулах, хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих, шаардлагатай илчлэг, шим тэжээл бүхий хоол хүнсээр хангах, норм, стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Дорнод аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн тогооч, эмч, нярвуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх “Хүүхдийн хоолны чанар, шим тэжээлийн байдлыг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газраас санаачлан Хэрлэн сумын 8 дугаар сургуульд зохион байгуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нарын заах арга зүйг нэмэгдүүлэх, туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 1, 4, 5 дугаар ангийн 92 багшийг хамруулсан сургалтыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газраас 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Хэрлэн сумын 1 дүгээр сургуульд зохион байгуулав.

Жайка олон улсын байгууллагын Тусгай хэрэгцээт боловсролын багш Тахара Хироми 2019 онд 3 бага ангийн багшийг дагалдуулан хамтарч ажилласан тухай, Хэрлэн сумын 11 дүгээр сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын багш Г.Төгсжаргал “Өглөөний тойрог хичээлээр тэгш хамруулан сургах нь”, Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн багш Э.Отгонцэцэг “Ганцаарчилсан хөтөлбөрийг боловсруулах арга зүй”, Хэрлэн сумын 11 дүгээр сургуулийн сургалтын менежер А.Мөнхцэцэг “Гурван минутын арга”, Хан-Уул цогцолбор сургуулийн багш Н.Нарангэрэл “Сурах бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдвээр өөрийн арга зүй, туршлагаасаа багш нарт түгээв.

“Боловсролын үнэлгээ, даалгаврын сангийн программ хангамжийг ашиглах нь” сэдэвт сургалт аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газарт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулагдав.

Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулж буй уг сургалтад тус газрын мэргэжилтнүүд, 27 сургуулийн шалгалтын даалгавар боловсруулагч сургалтын менежер нийт 34 оролцогч хамрагдав.

Дорнод аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл хангах зорилго бүхий “Эрчимжүүлсэн сургалт”-ын хөтөлбөр Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуульд хэрэгжиж байна. Хэрлэн сумын Үндэсний лаборатори Хан-Уул цогцолбор сургуулийн Физикийн багш Ц.Хоролжав, мөн сургуулийн Биологийн багш Б.Ариунтуяа нар, тус сумын мэргэжлийн багш нартай хамтран 60 цагийн сургалт зохион байгуулж байна. Энэ сарын 08-наас Англи хэл, Химийн хичээлээр дээрх агуулга бүхий сургалт явагдав.

### **Зөвлөмж, чиглэл:**

“Томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, тархалтыг бууруулах ажлыг эрчимжүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2019 оны А/655, “Сургуулийн өмнөх байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг түр хязгаарлах тухай” Хэрлэн сумын Засаг даргын 2020 оны А/01 дүгээр захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Хэрлэн сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, эмч нарт чиглэл өгөх уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, холбогдох зөвлөмж, чиглэлийг өгөв.

Дорнод аймгийн Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 22 эмч 2020 оны 01 дүгээр сарын 28-31-ний өдрүүдэд 86 байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа, үйлчилгээний газруудад 484 иргэдэд

зөвлөгөө өгч, коронавирусээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж бүхий 313 ширхэг плакат нааж, 1172 ширхэг хялбаршуулсан гарын авлага тараав.

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр 2006 оноос эхлэн Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Anna home” асрамж, халамжийн төв шинэ байрандаа орсонтой холбогдуулан сайн үйлсийн аяны хүрээнд цугларсан эд зүйлсийг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хүлээлгэн өгөв.

Тэнд амьдарч буй хүүхдүүдийн сурч, хөгжих орчин нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газраас санаачлан харъяа байгууллагууд болох Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хамтын оролцоотойгоор тус төвийн сургалтын танхимд оюуны хөрөнгө оруулалтыг хийв.

***Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар***

***“Өргөдөл, гомдол”-ын шийдвэрлэлтийн мэдээлэл:***

Хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлтийг хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 15 дуудлага, 3 өргөдлийг хүлээн авч, хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж ажилласан бөгөөд шийдвэрлэлт 65 хувьтай. “Гэр бүлд зөвлөгөө өгөх” танхимаар энэ сард нийт 7 иргэн, 17 удаагийн давтамжтай зөвлөгөө үйлчилгээ авсан байна.

“Нэг цэгийн үйлчилгээний төв”-д энэ сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 10 хүнийг 1-7 хоногийн хугацаатай байршуулж, аюулгүй байдалд хяналт тавин эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг үзүүлэн харьяа хамтарсан багт шилжүүлж, үйлчлүүлэгчтэй ажиллах кейс, төлөвлөгөө боловсруулан хариу үйлчилгээ үзүүлсэн. Насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэгт холбогдсон 1, гэрч 1 хүүхдийн байцаалтанд тус тус оролцож, хүүхдийн эрхийг ханган ажиллахаас гадна Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн үрчлэлтийн дүгнэлт гаргуулах саналын хүрээнд 2 өрхөд үнэлгээ хийж дүгнэлтийг хүргүүлсэн.

***Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:***

2020 оныг “Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын жил” болгох зорилт тавин, зорилтот жилийн хүрээнд 10 томоохон ажлыг төлөвлөн, төлөвлөгөө боловсруулаад байна.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээл ба тэгш боломж” 4 цагийн сургалтад байгууллагын 12 албан хаагчийн хамруулахаас гадна дотоод сургалтыг 1 удаа зохион байгуулж, сургалтаар “Гүйцэтгэлийн төлөвлөгөө

боловсруулах арга зүй”, “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн талаарх мэдээллийг албан хаагчдад хүргэж, мэдлэг олгосон. Мөн албан хаагчдын хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих зорилгоор байгууллагын уламжлалт “Цас мөсний баяр 2020” арга хэмжээг зохион байгуулж, нийт 22 албан хаагчийг хамруулан, тайланг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газарт хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны А/01 дугаар тушаалаар “Байгууллагын угтах үйлчилгээний журам”-ыг батлан албан хаагчдыг хуваарийн дагуу тогтмол ажиллуулж, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байна.

Архивын тухай хуулийн дагуу байгууллагын баримт бичиг, нягтлан шалгах комисс хуралдаж, байгууллагын 2019 оны архивын хадгаламжийн нэгжийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээн авч, архивт нийт 56 баримтыг хүлээлгэн өгч, архивлаад байна.

Орон нутгийн “Гэр бүлийн хөгжил, дэвшил” хөтөлбөрт хамрагдах өрхүүдийн бүртгэлийг авч, нэгтгэн, мэдээллийн сан үүсгэж, сонгосон гэр бүлтэй ажиллах бэлтгэл ажлыг хангаж байна.

### ***Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:***

Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт”-ыг цувралаар өсвөр үе, залуучууддаа тогтмол зохион байгуулж байна. Тайланд сард “Харилцаа хандлага, Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах, Стрессийг зохицуулах, өөртөө итгэх итгэл, Төлөвлөлт” сэдвээр 5 байгууллагын нийт 143 ажилтан, албан хаагч, сурагчдад сургалт зохион байгуулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй гэрээсээ гарах боломжгүй өсвөр үе, залуучуудыг нийгэмшүүлэх зорилгоор хэрэгжүүлдэг “Хүрч очих” үйлчилгээнд Хэрлэн сумын 6, 10 дугаар багийн 2 иргэн хамрагдаж, 2 удаагийн уулзалт, үйл ажиллагаанд хамрагдсан.

### ***Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс***

#### ***1. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:***

2020 оны 01 дүгээр сард нийгмийн даатгалын санд 2134198,4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2324308,4 мянган төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 108,9 хувийн биелэлттэй. 2020 оны 01 дүгээр сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт 1*

*Нийгмийг даатгалыг сангийн орлого  
/мянган төгрөг/*

<b>д/д</b>	<b>Төрөл</b>	<b>Төлөвлөгөө</b>	<b>Биелэлт</b>	<b>Хувь</b>
------------	--------------	-------------------	----------------	-------------

1	Тэтгэврийн даатгалын санд	1784967,4	1857541,2	104,1
2	Тэтгэмжийн даатгалын санд	169148,1	205562,7	121,5
3	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд	150218,0	217504,2	144,8
4	Ажилгүйдлийн даатгалын санд	29855,9	43700,4	146,4
	<b>Нийт</b>	<b>2134189,4</b>	<b>2324308,5</b>	<b>108,9</b>

## 2. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалтын талаар:

Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага 4739882,7 төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс тэтгэвэр авагч, даатгуулагчдад 4727105,7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардал олгож 99,7 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж,*

*төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө*

*Хүснэгт 2*

Д/д	Нийгмийн даатгалын сан	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Даатгуулагчдын тоо	Сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж (мян.төг)
1	Тэтгэврийн даатгалын сан	Өндөр нас тэтгэвэр	8548	3018388,3
		Тахир дутуугийн тэтгэвэр	2759	778159,4
		Тэжээгчээ алдсны тэтгэвэр	608	177051,0
		Цэргийн алба хаасны тэтгэвэр	582	351532,9
2	Тэтгэмжийн даатгалын сан	Хөдөлмөрийн чадвар түр алдсан тэтгэмж	167	15058,0
		Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	128	184840,7
		Оршуулгийн тэтгэмж	39	39000,0
3	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан	Тахир дутуугийн тгэвэр	63	27257,9
		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	15	6017,5
4	Ажилгүйдлийн даатгалын сан	Тэтгэмж	40	129800,0
		Сургалтын зардал	0	0
	Нийт дүн		12949	4727105,7

2020 оны 01 дүгээр сарын байдлаар 12949 тэтгэвэр авагч, даатгуулагч, 4727105,7 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан

бүрэн олгож, тэтгэвэр авагч, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэлээ.

### **3. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:**

2020 оны 01 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 559502.6 мянган төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 84,1 хувь буюу 470542,7 мянган төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага 15,9 хувь буюу 88959,9 мянган төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна. Нийт авлагын 33,8 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.



#### **Оны эхний авлагаас:**

2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 100 байгууллагын 550491,6 мянган төгрөгийн авлагаас нийт 44 байгууллагын 102799,9 мянган төгрөгийн авлага барагдуулсан.

#### **Нийт барагдуулсан:**

2019 онд Шүүхэд нэхэмжлэл гаргасан 7 байгууллагын төгрөгөөс 26046,6 мянган авлагыг бүрэн барагдуулаад байна.

Эргэн төлөгдөх найдваргүй авлагад “Эетэнүүн” ХХК, “Дорнын ариун хүнс” ХХК-уудын нийт 5446,3 төгрөгийн авлагын судалгаа гаргаж, хувийн хэргийн баяжилтыг хийж, материалуудыг бүрдүүлэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт шийдвэрлүүлэхээр хүргүүлээд байна.

### **4. Нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх өөрчлөлтүүдийн хэрэгжилтийн талаар:**

#### **1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх талаар:**

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Хуулийн үйлчлэлд тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн төлөх хүсэлт гаргасан 15-60 настай Монгол Улсын иргэн хамаарах бөгөөд шимтгэл төлөх хугацаанд иргэний суралцсан, хорих ял эдэлсэн, өндөр насны тэтгэвэр авсан хугацаа хамаарахгүй. Шимтгэлийг хуулийг дагаж мөрдөх үеийн буюу одоогийн хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээний 10 хувиар буюу сард 42000 (420000х10 хувь) төгрөгөөр тооцож төлөхөөр байна.

Хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан журам, зааврын дагуу аймгийн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сард 15 иргэний 31,9 сая төгрөгийн шимтгэлийг тэтгэврийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

## **2. Зарим иргэний тэтгэврийг 50 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх талаар:**

Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Хуулийн үйлчлэлд 1990 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр баталсан БНМАУ-ын Тэтгэврийн хуульд заасан доор дурдсан болзол, нөхцлөөр 1991 оны 01 дүгээр сарын 01-нээс 1994 оны 12 дугаар сарын 31-ний хооронд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон зарим иргэн хамаарна.

1. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн, 15-аас доошгүй жил ажиллаж 50 насанд хүрсэн нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эх,

2. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн, 20-оос доошгүй жил нас харгалзахгүй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эх,

3. Нийтдээ 27-гоос дээш жил ажиллаж нас харгалзахгүй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эмэгтэй,

4. Нийтдээ 32-оос дээш ажиллаж 55 насанд хүрсэн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эрэгтэй.

Аймгийн хэмжээнд уг хуулийн үйлчлэлд 1017 иргэн хамрагдаж 50,8 сая төгрөгийг 2020 оны 01 дүгээр сарын тэтгэвэр дээр нэмж олгосон болно.

## **3. Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн тоогоор 1 жил 6 сар нэмж тооцдог болсон талаар:**

Төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл нь хүүхдээ өгсөн эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сарын нэмж тооцно. Хуулийн үйлчлэлд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгох эхчүүдэд хамаарах бөгөөд энэ заалт нь зөвхөн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаанд хамаарах ба хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд, малчнаар, мэргэжлийн урлагийн байгууллагад ажилласан, цэргийн албан хаасан зэрэг тусгай нөхцөлийн жилд хамаарахгүйн хэмжээнд 2020 оны 01 дүгээр сард нийт 297 иргэнд шинээр тэтгэвэр тогтоосон. Үүнээс:

- Өндөр насны тэтгэвэр 242, (цэргийн алба хаасны 1, малчин 17, хүүхдээр 153, хүнд нөхцөл 4, бусад 66)



- Тахир дутуугийн тэтгэвэр 48,
- Тэжээгч алдсны тэтгэвэр 7,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5-д зааснаар төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор 1 жил 6 сарыг шимтгэл төлсөн хугацаанд тооцох заалт хэрэгжиж эхэлснээр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тоо өмнөх сарын дунджаас 3,7 дахин буюу 210 тэтгэвэр авагчаар өссөн үзүүлэлттэй байна.

Энэ оны 1 дүгээр сард нийтдээ 232 даатгуулагч нийт шимтгэл төлсөн хугацаанд төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн тоогоор 1 жил 6 сарыг нэмэгдүүлэн тэтгэвэр тогтоолгосны 153 нь 4.2-д заасан /4-өөс дээш хүүхэд/ нөхцлөөр өндөр насны тэтгэврээ тогтоолгосон байна.

#### ***4. Хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхийн шимтгэл төлөлт тасрахгүй байх нөхцөл бүрдсэн талаар:***

- Хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөтэй байгаа эхийн нийгмийн даатгалын шимтгэлийг дараахь байдлаар төлөхөөр зохицуулсан. Үүнд:
- Албан журмын буюу ажил хөдөлмөр эрхэлж байсан эхийн төлөх шимтгэлийг ажил олгогчоос,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу жирэмсний болон амаржсны тэтгэмж авах эрх нь үүссэн сайн дурын даатгуулагч эх шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн нөхцөлд 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас,
- Бусад эхийн шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн нөхцөлд 50 хувийг улсын төсвөөс хариуцан төлнө.

Уг хуулийн үйлчлэлд аймгийн хэмжээнд 130 эхийг хамруулан шимтгэлийн хөнгөлөлт эдлүүлээд байна.

#### ***5. Сайн дурын даатгуулагч эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 100 хувиар тооцож олгох талаар:***

Хуулийн зохицуулалтын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сайн дурын даатгуулагч эхэд жирэмсний болон амаржсны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлсөн 12 сарын орлогын дунджаас 70 хувиар боддог байсан бол 100 хувиар тооцон олгож эхэллээ.

Уг хуулийн үйлчлэлд хамрагдсан 43 даатгуулагч эхэд 26700,0 мянган төгрөг олгосон бөгөөд үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8000,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

## **5. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах:**

Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан уг хуулийн үйлчлэлд хамаарах 1051 тэтгэвэр авагчийн хувийн хэрэгт байгаа бичиг баримтыг нэг бүрчлэн тулган шалгав.

Дээрх иргэдийн материалыг шалгаж үзэхэд 1017 иргэн уг хуулийн үйлчлэлд хамаарах нь тогтоогдсон байна.

Түүнчлэн “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах хяналт, шалгалтыг ажлыг зохион байгуулсан. Үүнд:

- ❖ Тэжээгчээ алдсны тэтгэврийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн регистрийн дугаар мэдээллийн санд үнэн зөв бүртгэгдсэн,
- ❖ Тэтгэвэр авагч 19 насанд хүрсэн эсэхийг 192 тэтгэвэр авагчийн материалд нягтлан шалгаж баталгаажуулсан.
- ❖ Хөдөлмөрийн чадвар алдалтыг хугацаагүйгээр сунгасан тахир дутуугийн тэтгэвэр авагч 73 иргэний материалыг сунгалтыг дахин шалгасан.

## **6. Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах:**

- ❖ Байцаагч, ажилтнуудыг мэргэшүүлэх буюу хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх нэг мөр ойлголттой болгох сургалтыг зохион байгуулж, нийт байцаагч, ажилтнуудыг хамруулсан,
- ❖ Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар сургалтыг 20 ажил олгогч байгууллагын нийт 869 даатгуулагчид зохион байгуулсан.
- ❖ Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс пэйж хуудсаар дамжуулан хууль тогтоомжийн өөрчлөлт, хэлтсийн үйл ажиллагааны талаар нийт 17 удаагийн мэдээ, мэдээлэл, нийтлэлээр нийт 181530 иргэний хандалт авч мэдээллээр ханган ажилласан.
- ❖ Орон нутгийн 2 телевизээр дамжуулан 2 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж иргэдийг мэдээллээр ханган хамтран ажилласан

## **7. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлал комиссын үйл ажиллагаа:**

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс 5 удаа хуралдаж, 281 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 40 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан, 190 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 51 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна.

Цуцлагдсан 40 иргэний 25 нь өндөр насны тэтгэвэр тогтоолсон, 9 нь заалтын хугацаа дууссан, 6 нь эмчлэн эрүүлжсэн байна.

***Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг***

## ***Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар***

### ***Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний чиглэлээр:***

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 1188 иргэнээс 82 иргэн тухайн сард шинээр бүртгэгдэж, 29 иргэн байнгын ажлын байранд зуучлагдснаас 23 нь шинэ ажлын байраар хангагдсан байна. Ажил хайгч 32 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах хүсэлтэй 2 аж ахуйн нэгжийн 868 иргэний хүсэлтийг хүлээн авч судлан 4 иргэнийг орон нутагт хөдөлмөр эрхлүүлэхээр дэмжиж, 864 иргэний холбогдох баримт бичгийг судалж байна.

Европын холбооны “Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх” /SECiM/ төслийн санхүүжилтээр “Халамжаас хөдөлмөрт” зорилтын хүрээнд залуусын ажил хийх хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, тулгарч байгаа асуудлаа хэрхэн шийдвэрлэх арга замыг харуулсан цуврал теле зохиомж 2 анги, “Хөдөлмөрийг өөрөөсөө” чөллэнжийн 6 дугаар хэсгийг тус тус олон нийтийн хүртээл болгоод байна.

Мөн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсгийн 3 дахь удаагийн хэлэлцүүлгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан.

Хэлэлцүүлэгт аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл, урлагийн газар, Дорнод их сургууль, Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Залуучуудын холбоо, SECiM төслийн хяналт-үнэлгээний зөвлөх Я.Очирсүх нар оролцож бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгах саналын талаар хэлэлцэв.

### ***Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:***

Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, 2019 оны Старт-ап бүлэг хамтран “Дорнодод үйлдвэрлэв” нэгдсэн цэг бий болгох ажлыг нутгийн үйлдвэрлэл эрхлэгчид, аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 50 гаруй төлөөлөлд танилцуулж, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хугацаа хэтэрсэн эргэн төлөлтийн мэдэгдэх хуудсыг хүлээлгэн өгөх ажлыг хэлтсийн хэмжээнд зохион байгуулж ажилласан.

### ***Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээл олгох үйлчилгээ:***

Дэлхийн банкны санхүүжилтээр “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих” жижиг зээлийн санхүүгийн өмнөх сургалтад 86 иргэний хамруулж, 57 иргэнийг төслийг Төрийн банканд хүргүүлсэн. Үүнээс: 7 иргэний 63,8 сая төгрөгийн зээл буцаагдаж, 5 иргэний 39,5 сая төгрөгийн зээл судлагдаж байна.

18 иргэнд 175,0 сая төгрөгийг олгож, 28 ажлын байрыг хадгалагдаж байна. “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих” жижиг зээлд хамрагдсан 18 иргэнээс 9 иргэнийг зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамруулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2018 онд олгогдсон “Жижиг зээл”-ийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс 3 иргэний 35,0 сая төгрөгийн төслийг дэмжин Төрийн банкинд хүргүүлсэн.

### ***Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хүрээнд:***

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/64 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах болзолт уралдаанд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газар, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, Политехник коллежийн материалыг салбар салбарын яаманд хүргүүлсэн.

### ***Нийгмийн халамжийн чиглэлээр:***

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1802 иргэн хамрагдаж 310,7 сая төгрөг, асаргааны тэтгэмжид 1341 иргэнд 108,0 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 264 иргэнд 50,9 сая төгрөг, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжид 4915 иргэнд 231,8 сая төгрөг, ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлт тусламжид 56 иргэнд 10,2 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтөд 469 иргэнд 39,3 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламжид тус тус хамруулсан.

Алдар цолтой ахмад настанд улсын төсвөөс олгож байгаа тусламж, хөнгөлөлтөд Улсын ударник, гавъяат, төрийн өндөр албан тушаал хашиж байсан 30 ахмад настанд улсын төсвөөс 4,6 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлтөд хамруулсан.

### ***Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжил, хамгаалал:***

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2 удаа хуралдаж, 17 хүүхдийн асуудлыг хэлэлцэн 4 хүүхдийн байнгын асаргааг тогтоож, 3 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, 10 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэсэн. Мөн салбар комиссын 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

### ***Өрхийн мэдээллийн сангийн өргөдөл, гомдол хүүхдийн мөнгөн тэтгэмж:***

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд 256 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч бүртгэн ажиллав. Үүнээс өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдахыг хүссэн 231 өргөдөл, амьжиргааны түвшингийн тодорхойлолт авахыг хүссэн 35 өргөдөл байна.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдах 231 өргөдлөөс тухайн сард 141 өргөдөл шийдвэрлэсэн.

Амьжиргааны түвшний 409,679 босго шугамаас доогуурт багтсан 35 иргэнд тодорхойлолт олгож ажиллав.

Шинээр төрсөн 284 хүүхдийн мэдээллийг төрсний гэрчилгээний хуулбарыг үндэслэн өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдах боломжийг бүрдүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 96 дугаар тогтоол, Засгийн газрын 470 дугаар тогтоолоор хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрт хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох чиглэлийн дагуу өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг шуурхай зохион байгуулж байна.

### ***Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ:***

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд Хэрлэн сумын 1751 өрхийн 5120 том хүн, 4527 хүүхдэд нийт 9647 хүнд хүргэж тухайн сард 118,1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хэрлэн сумын хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг гэрээ байгуулсан хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналтын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэстэй хамтран 2020 оны 01 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд хяналт шалгалт хийсэн.

### **Сургалт:**

Япон Улсын “Жайка” Олон Улсын байгууллага, “Det forum” төрийн бус байгууллага хамтран хөгжлийн бэрхшээлийн иргэдийн талаарх ойлголт, нийгмийн хандлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг хэрхэн ижил тэгш, хүртээмжтэй хүргэх чиглэлээр Дорнод аймгийн нийгмийн хамгааллын салбарын 86 ажилтан, албан хаагчдад “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтыг зохион байгуулснаар хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг өөрчлөгдсөн.

### **Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг**

#### **Эрүүл мэндийн газар:**

#### **Эм, эмнэлгийн хэрэгслийн суурь үнийн судалгаа:**

Аймгийн Засаг даргын 2020 оны А/38 дугаар захирамжаар байгуулагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналт газрын Эм, био бэлдмэлийн хяналтын Улсын байцаагч, Эрүүл мэндийн газрын Хяналт-үнэлгээний мэргэжилтэн, Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан хувийн хэвшлийн 15 эмийн сангаас томуу, томуу төст өвчний үед хэрэглэгдэх шаардлагатай 39 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн суурь үнийн судалгаа хийсэн.

#### **“Аз жаргал” төв:**

Аймгийн Засаг даргын 2020 оны А/30 дугаар захирамжийн хүрээнд “Аз жаргал төв”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагааны бэлтгэл байдлыг ханган ажиллаж байна.

#### **Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх:**

Шинэ коронавирусын цаг үеийн мэдээлэл, коронавирусын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх сэдвээр 166 төрийн байгууллага болон аж ахуй нэгжийн 1124 ажилтан, албан хаагчид сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа хийсэн.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн эмч нар, “Монголын Улаан загалмай нийгэмлэг” Үндэсний хүмүүнлэгийн байгууллагын Дорнод аймгийн хорооны сайн дурын идэвхтнүүд хамтран аймаг, сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчдад шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авснаас хойш 36 удаагийн давталтаар 3115 хүнд сургалт, 9058 ширхэг гарын авлага тарааж, 1172 сурталчилгааны материалыг олон нийтийн газрууд болох дэлгүүр, зах, худаг, зоогийн газар, караоке, зочид буудал, албан байгууллагын нүдэнд харагдахуйц хэсэгт тус тус байршуулсан.

### ***Эрүүл аюулгүй орчинд ажиллах зан үйл:***

“Дорнод нийтийн аж ахуй” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт Эрүүл, аюулгүй орчинд ажиллах зан үйлийг иргэдэд төлөвшүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн түүнд тавигдах шаардлага, мэргэжлээс шалтгаалах өвчний тухай ойлголт, урьдчилан сэргийлэх арга замын сургалт 150 ажилтанд зохион байгуулсан.

### ***Хоолны зардлын норматив тогтоох тухай***

“Хоолны зардлын норматив тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд Хэрлэн сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын тогооч нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжих, шаардлагатай илчлэг, шим тэжээл бүхий хоол хүнсээр хангах, норм, стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллээр хангах, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад өгч байгаа үдийн цай, цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанар, хоолны цэсны тухай мэдээлэл өгч ажилласан.

### ***Халдварт бус өвчинтэй тэмцэх:***

“Халдварт бус өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн хүрээнд оюутны эрүүл мэндийг дэмжих, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх “Эрүүл-Оюутан” төслийг зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.



## **Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР**

### **МАЛ АЖ АХУЙ:**

**Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил, үйлчилгээний нэгжид төвлөрүүлэх чиглэлээр Баянтүмэн суманд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан тухай:** Баянтүмэн суманд загвар Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид төвлөрүүлэх зорилгоор ахмад мал зүйчид болон хуц, ухна малладаг малчид нийт 18 иргэнд Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил, үйлчилгээний нэгжид төвлөрүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, санал бодлыг сонсож ажиллаа.

**Малын шилжилт хөдөлгөөний судалгаа гаргасан тухай:** Аймгийн хэмжээнд 2017-2019 онуудад гаднаас шилжиж ирсэн болон отроор өвөлжиж байгаа малчдын судагааг гаргалаа. 2017 онд 39 малчин өрхийн 88 хүн, 2018 онд 34 малчин өрхийн 68 хүн, 2019 онд 29 малчин өрхийн 52 хүн нийт 96 малчин өрхийн 208 хүн шилжиж ирсэн байна. Шилжиж ирсэн малчин өрх нь 15 өөр аймаг шилжиж ирсэн бөгөөд Төв аймгийн 12 сумаас 31 малчин өрх, Улаанбаатар хотын 7 дүүргээс 19 өрх, Сэлэнгэ аймгийн 5 сумаас 9 өрх шилжиж ирсэн байна. Шилжиж ирсэн малчин өрхийн байршлыг гаргасан.

**Арьс, ширний урамшуулал:** Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу арьс, ширний урамшуулалд аймгийн хэмжээнд 13 сумын 686 малчин, мал бүхий өрх хамрагдаж богын арьс 74,377 ширхэг, бодын шир 13,694 ширхэг нийт 88,071 ширийг үндэсний үйлдвэрт тушааж 428,5 сая төгрөгний урамшууллын материал бүрдүүлээж Мал мал хамгаалах сангийн программд оруулаад байна.

**Улсын аварга малчны материалыг хүргүүлэв:** Монгол улсын Засгийн газрын 2019 оны 338 дугаар тоот Улсын аварга малчин өрх” шалгаруулах журмыг дагуу 12 сумын 13 малчны материалыг нэгтгэж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 1 хошой аварга, 5 Улсын аварга малчин өрх , нийт 6 малчны материалыг хүргүүлж ажилласан.

Монголын үндэсний олон нийтийн радиогийн Нийгмийн Нэвтрүүлгийн Редакц “Таван Эрдэнэ” нэвтрүүлэгийн нэрэмжит “Алтан төлийн эзэн” шалгаруулах журмын дагуу 4 сумын 4 малчны материалыг “Алтан унага”, “Алтан тугал”, “Алтан хурга”, “Алтан ишиг”-ны эзэнд шалгаруулахаар материалыг нь хүргүүллээ.

### **ГАЗАР ТАРИАЛАН:**

Атрын 60 жилийн ойн хүрээнд Хөдөлмөрийн гавъяаны улаан тугын одон-4, Алтан гадас одон-8, Хөдөлмөрийн хүндэт медаль-12, Атарчдын алдар медаль-70, нийт 10 сумын 94 иргэний материалыг нэгтгэн хүргүүлэв.

Улсын аварга тариаланч-1, тариаланч хамт олон-1 материалыг Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ХХААҮЯ-нд хүргүүлсэн.

Аймгийн Аварга тариаланч, тариаланч хамт олон шалгаруулах журмын төслийг боловсруулсан. Сумдаас 2019 оны аймгийн аварга тариаланч, тариаланч хамт олны материалыг хүлээн авлаа. Үүнд. 1 хамт олон, 5 тариаланч

Манай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа үр тарианы аж ахуйн нэгж 2019 онд дотоодын гурилын үйлдвэрүүдэд 15.5 мянган тн товарын улаан буудайн тушаагдсан. Үндэсний үйлдвэрт тушаасан буудайн урамшуулалын материалд ХХААХҮ-ийн сайдын "Дотоод аудит хийх тухай" 2020 оны 01 сарын 15-ны өдрийн А-20 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тариалангийн аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж өгсөн.

### **ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Дорнод аймгийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн судалгааг 2019 оны жилийн эцсийн байдлаар авч судалгааг нэгтгэхэд Гурилын – 2, гурилан бүтээгдэхүүний – 57, Хагас боловсруулсан бүтээгдэхүүний 15, Усны – 5, архи пивоны – 1, тахианы аж ахуй – 1, зөгийн аж ахуй – 8, мах ангилах – 6, махан бүтээгдэхүүний 7, сүүн бүтээгдэхүүн боловсруулах 17, нийт 119 үйлдвэр байна.

**Хүнсний бүтээгдэхүүний үнэ:** Хүнсний 19 нэр төрлийн бүтээгдэхүүний үнийг 8 цэгээс авч 7 хоног бүрийн Лхагва гарагт ЗДТГ-ын ХОХӨТХ-т хүргүүлж ажиллаж байна.

Худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр хөдөөгийн 13 суманд нийт гуанз 32, баар 10, кафе 2, караоке 1 үйл ажиллагаа явуулж байна.

Худалдааны чиглэлээр супермаркет 11, минимаркет 19, хүнсний дэлгүүр 99, барилгын материалын дэлгүүр 1, барааны дэлгүүр 4 ажиллаж байна.

**Хуванцар сав:** Хүнсний шингэн бүтээгдэхүүнийг нөөцлөхөд ашиглаж буй гарал үүсэл тодорхойгүй хуванцар савны хэрэглээг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулахад ашиглах суурь судалгааг 14 сумын 3073 өрхийг хамруулан аваад байна.

**Хөнгөн үйлдвэр:** Аймгийн хэмжээнд арьс, ширний үйлдвэрлэл 19, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл 13, оёдлын үйлдвэрлэл 98, хэвлэлийн үйлдвэрлэл 14, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл 3, барилгын материалын үйлдвэрлэл 41, мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 86 буюу нийт хөнгөн үйлдвэрийн салбарт 271 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

### **ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**“Дорнодод үйлдвэрлэв” брэнд бүтээгдэхүүний нэгдсэн цэгийг бий болгох уулзалтыг зохион байгууллаа:** Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ын дарга Х.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэл, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Алимаа, Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Н.Энхболд болон холбогдох албаны хүмүүс, орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх брэнд бүтээгдэхүүний нэгдсэн цэг бий болгох зорилгоор **“Дорнодод үйлдвэрлэв”** уулзалтыг зохион байгуулсан.

Уулзалтанд залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан Старт-ап бүлгийн 60 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллүүд оролцож “Дорнодод үйлдвэрлэв” бүлгийн ахлагч “Жуулчин” дэлгүүрийн мэдээллийг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд танилцуулав.

**Үр дүн:** Чойбалсан хотод 2 дугаар багийн нутагт байрлах "ЕF" хүнсний сүлжээ дэлгүүр болон Тээврийн бирж дээр Дорнодын брэндүүдийг худалдан борлуулах цэгийг хоёроор нэмэгдүүлж, нийт 3 цэгтэй болох юм.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол “Хоолны зардлын норматив тогтоох тухай”-ийг тогтоолоор Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын төсвийг нэмэгдүүлсэн холбоотой мэдээллээр хангах сургалтад “Хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн талаар ерөнхий мэдээлэл” сэдвээр мэдээлэл өглөө.

Сургалтын үеэр:

1. Сүүний хэрэгцээ тогтвортой биш байдаг, үүний улмаас үнэтэй пакеттай сүү хэрэглэж байна.
2. Хүнсний ногоог нийлүүлэгч янз бүрийн чанартай төмс, хүнсний ногоо хольж нийлүүлж байна зэрэг санлууд гарч хэрэгжүүлэх болон зөвлөх боломжуудын талаар санал авч ажилласан.

Сургалтад Хэрлэн сумын ЕБСургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, хүнсний нярав, эмч, ахлах тогооч нийт 148 хүн хамрагдсан.

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР:** Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн байгууллагын үйл ажиллгаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/159 дүгээр тушаалар баталсан салбарын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шижилгээ үнэлгээ хийх аргачлалын дагуу 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг хугацаанд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн Засаг даргын тамгын газар, Мал эмнэлгийн ерөнхий газарт тус тус хүргүүлж ажилласан.

Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран сумдаас малын шилжилт хөдөлгөөний судалгааг авч “Малын шилжилт хөдөлгөөний журам”-ын төслийн боловсруулан ажлын хэсэгт хүргүүлэв.

Орон нутгийн төсөвт тусгагдсан “ Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэлд цахим систем нэвтрүүлэх” нэвтрүүлэх ажлын техникийн тодорхойлолт боловсруулан Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд 2020 онд мал эмнэлгийн үйл ажиллагаанд шаардлагатай эм, вакцины тооцоог гаргав.

Сумдын мал эмнэлгийн тасгуудад өвчин гарсан үед бэлэн байдалд ажиллаж чиглэл өгч шаардлагатай вакцин, хувцас хэрэглэлийн хүргүүлэв.

## **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХҮРЭЭНД**

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2020 оны 01 дүгээр сарын 20-нд сумдын байгаль хамгаалагчын нэгдсэн уулзалт, сургалт зохион байгууллаа. Сургалтаар байгууллагын 2020 оны төлөвлөгөөт ажлууд, тэдгээрийг гүйцэтгэх, зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавихад анхаарах асуудлууд, байгаль орчны салбарын холбогдох эрхзүйн баримт бичиг, түүний шинэчлэлт, тайлан мэдээ гаргах, бичиг баримт боловсруулахад анхаарах зэрэг байгаль хамгаалагчдын ажил, мэргэжилд шаардлагатай мэдээллүүдээр тус газрын мэргэжилтнүүд холбогдох сургалт, зөвлөмж өглөө.

Мөн аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний албанаас “Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-ийн 2019 оны ажлын танилцуулга болон Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тооллого явуулах шинэ журмыг танилцуулж, тооллогын ажилд 2 байгууллага хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон.

Шинээр батлагдсан Байгаль орчныг хамгаалах маягт, тэдгээрийг нөхөх заавар, байгаль орчны статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалыг анхан шатны мэдээ, мэдээлэл цуглуулагчдад танилцуулах сургалтад 1 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд 8 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдаж Байгаль орчны хяналтын маягтыг бөглөх аргачлалд суралцсан

Уг сургалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг газар, Азийн хөгжлийн банктай хамтран зохион байгуулсан бөгөөд Хэрлэн, Баян-Уул, Баянтүмэн, Хөлөнбуйр сумдын байгаль хамгаалагчид, сум дундын ойн ангийн техникч, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн, биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн нар хамрагдаж холбогдох мэдээллийг авсан.

Сургалтын үр дүнд бусад сумдын байгаль хамгаалагч нарт Байгаль орчныг хамгаалах маягт бөглөх зааварчилгаа өгч 2 дугаар сарын 15-ны дотор бүх маягтыг бөглөж мэдээллийн санд оруулахаар шийдвэрлэсэн.

Чойбалсан хотын хог хаягдлын менежментийг сайжруулах талаар төсөл бичиж БОАЖЯаманд хүргүүлэх талаар аймгийн Засаг даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу Хэрлэн сумын орлогч дарга О.Пүрэв-Очир, Чойбалсан хотын захирагчийн албаны дарга П.Оюундэлгэр, “Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-ын дарга Б.Тэгшжаргал болон холбогдох мэрэгжилтнүүд уулзалдаж төслийн санал хүсэлтээ солилцлоо.

Мөн Хэрлэн сумын 1, 5 дугаар багийн Засаг дарга, зохион байгуулагч нартай хамтран тус багуудад үүссэн хур хог хаягдлын 10 цэгийг газар дээр нь үзэж танилцан ажлын даалгаврын төсөл боловсруулаад байна.

